ГЭРЭЭНИЙ ТӨСӨЛ ХЯНАСАН АКТ

Огноо:	2022 оны 02 сарын 25
Гэрээний нэр:	Зээлийн гэрээ
Гэрээний дугаар:	ЭМГЛ- 02/БТ-02/20220225
Гэрээний товч утга:	Эргэлтийн хөрөнгийн зориулалтаар "Өмнөговь аймгийн Тавантолгой-Гашуунсухайт" чиглэлийн 239 км хатуу хучилттай автозамын зам ашиглалтын орлогыг барьцаалах тухай
Харилцагч иргэн, байгууллага:	Байгууллагын банк хариуцсан захирал Б.Еркин
Гэрээний төсөлд санал өгсөн мэргэжилтэн:	Хууль, дүрэм журмын хэрэгжилт хариуцсан хуулийн мэргэжилтэн Г.Гандуулга
Гэрээний хэрэгжилтийг хариуцах газар, мэргэжилтэн:	Санхүүгийн тайлагнал хариуцсан мэргэжилтэн Ү.Уранбилэг
Төсөв:	3,000,000,000 /гурван тэрбум төгрөг/

ХЯНАСАН, ТАНИЛЦСАН:

Албан тушаал/Овог нэр	Гарын үсэг	Огноо
Салбарын үйл ажиллагаа хариуцсан дэд захирал Л.Энхболд		2022.02.25
Захиргаа хариуцсан дэд захирал Ц.Цолмон		2022.02.25
Хянан нийцүүлэлт хариуцсан хуулийн ахлах мэргэжилтэн Б.Болор		2022.02.25
Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогчийн түр орлон гүйцэтгэгч А.Мөнхтуяа		2022.02.25

ТӨСӨЛ БОЛОВСРУУЛСАН:

Хууль, дүрэм журмын хэрэгжилт хариуцсан хуулийн мэргэжилтэн Г.Гандуулга

ХАСБАНК

ХасБанк Маягт 01410

ЗЭЭЛИЙН ШУГАМЫН ГЭРЭЭ

2022 оны **02** дугаар сарын **24**-ний өдөр **№ ЗГ5004912848** Улаанбаатар хот

Энэхүү Зээлийн шугамын гэрээ /цаашид "Гэрээ" гэх/-г Монгол Улсын Иргэний хуулийн 451-453, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 19-27 дугаар зүйлийг тус тус үндэслэн нэг талаас Улаанбаатар хотын Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Ерөнхий Сайд Амарын гудамжны ХасБанкны төв байр хаягт оршин байх **ХасБанк** (улсын бүртгэлийн дугаар: **9016001007**, регистрийн дугаар: **2578697**) /цаашид "Банк" гэх/, нөгөө талаас СБД, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө 15, 15-р давхар тоот хаягт оршин байх Зээлдэгч **ЭРДЭНЭС МОНГОЛ ХХК** (улсын бүртгэлийн дугаар: **9011014002**, регистрийн дугаар: **5124913**) /цаашид "Зээлдэгч" гэх/ нар харилцан тохиролцож дараах нөхцлөөр байгуулав.

НЭГ. ГЭРЭЭНИЙ ЗОРИЛГО

1.1. Энэхүү Гэрээгээр Банк нь Зээлдэгчид тодорхой хугацаанд, зээлийн эрхийн дээд хэмжээг заах байдлаар хүү, шимтгэл, үүргийн гүйцэтгэлийг хангах арга, зориулалттайгаар мөнгөн хөрөнгө зээлдүүлэх, Зээлдэгч эрхийг олгогдсон хэмжээний дотор хэрэгжүүлэх, зээлийн хүү, шимтгэл хэрэв тооцогдсон бол нэмэгдүүлсэн хүүгийн хамт эргэн төлөхтэй холбоотой харилцаанд талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлно.

1.2. Талуудын тохиролцоог нарийвчлан тодорхойлсон тул үүсэх харилцаанд уг Гэрээг, Гэрээгээр тухайлан тохироогүй асуудалд Монгол Улсын Иргэний хууль, Банкны тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль болон холбогдох бусад хууль, журам, зааврыг баримтална.

ХОЁР. ЗЭЭЛИЙН ГОЛ НӨХЦӨЛ

2.1. Зээлийн эрхийн дээд хэмжээ\валютын төрөл: **3,000,000,000** (Гурван тэрбум) **төгрөг** байна. Зээлдэгч энэхүү Гэрээний хугацаанд Хавсралт 1-т заасан эрхийн хэмжээний дотор зээл авах, эргэн төлөх харилцааг хэдэн ч удаа үүсгэж болно.

2.2. Хугацаа: Зээлийг нийт **9** сарын хугацаанд, Зээлийн шугамыг төлөх нөхцөл (Хавсралт 1)-ийн дагуу хэсэгчлэн төлөх байдлаар ашиглана. Зээлийн шугамыг төлөх нөхцөл нь зөвхөн үндсэн төлбөрт хамаарна.

2.3. Хүү (Үндсэн болон хэтэрсэн хугацааны): Жилийн буюу 365 хоногт тогтмол **14.4** хувь байна.

2.4. Үүрэг хүлээсний шимтгэл: Ашиглаагүй зээлийн эрхийн үлдэгдэлд жилийн буюу 365 хоногт **3** хувь байна.

2.5. Зээлдэгч нь 2.3-д заасан Хүү, 2.4-т заасан Үүрэг хүлээсний шимтгэлийг сараар тооцож төлөх бөгөөд тухайн сарын төлөлтийг дараа сарын 2-ны өдрийн дотор Банкинд төлнө.

2.6. Нэмэгдүүлсэн хүү: Гэрээний хугацаа дуусахад ашигласан зээлийн үлдэгдэлтэй, түүнчлэн Хавсралт 1-т заасан зээлийн эрхийн хэмжээнээс ашигласан зээлийн үлдэгдэл хэтэрсэн тохиолдолд нэмэгдүүлсэн хүү төлөх ба нэмэгдүүлсэн хүү нь тухайн хугацаа хэтэрсэн зээлийн төлбөрт ногдох үндсэн хүүгийн 20 хувьтай тэнцүү байна.

2.7. Зориулалт: Эргэлтийн хөрөнгийн санхүүжилт байна.

2.8. Зээлийн шугамын дансны дугаар: **5004912848**. Зээлийн шугамын эрх нь энэхүү Гэрээ хүчин төгөлдөр болж, 2.10-т заасан гэрээнүүд 2.12-т заасан холбогдох эрх бүхий байгууллагуудад бүртгүүлж, зээл олголттой холбоотой нөхцөлүүд биелсэнээр 2.1-т заасан эрхийн дүнгээр энэ дансанд нээгдэнэ.

2.9. Зээл олгох хэлбэр: Ашиглах боломжит зээлийн шугамын эрх нээгдсэнээс хойш Зээлдэгч нь өөрийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн эрхийн зарцуулалтаар хэрэгжүүлнэ. Зээлийн шугамын данснаас зарлагын гүйлгээ хийгдсэнээр зээлийг олгосонд тооцно.

2.10. Үүргийн гүйцэтгэлийг хангах арга: Зээлдэгч, Хамтран үүрэг гүйцэтгэгч нь энэхүү Зээлийн шугамын гэрээний үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүй нөхцөлд үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар **2022** оны **БГ5004912848-01** дугаартай Барьцааны гэрээг байгуулсан болно.

2.11. Зээлийн үйлчилгээний шимтгэлийг Гэрээнд заасан зээлийн эрхийн дээд хэмжээний **0.10** хувь, гэрээний явцад нөхцөл өөрчлөх тохиолдолд нийт зээлийн эрхийн дүнгээс **1,000,000** төгрөгөөр тус тус тооцно.

2.12. Зээлдэгч хүсвэл энэхүү Гэрээг нотариатаар гэрчлүүлж болох ба ийнхүү гэрчлүүлэх, 2.10-т заасан дагалдах Гэрээг Улсын бүртгэл, Цахим мэдээллийн сан, Автотээврийн үндэсний газар, Газрын алба зэрэг холбогдох байгууллагад бүртгүүлэх хураамж, төлбөр болон гарах бусад зардлыг Зээлдэгч хариуцна.

2.13. Зээлийн шугамын эрхийг түр хаах, сэргээх: Зээлдэгч Гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн, зээлийн хүү, үүрэг хүлээсний шимтгэл болон үндсэн төлбөрийн хугацаа хэтрэлт үүссэн тохиолдолд Банк зээлийн шугамын эрхийг түр хаах, шинээр дахин эрх нээх болон зээл олгохоос татгалзах эрхтэй.

2.14. Банк нь хүүгийн хувь хэмжээ өөрчлөгдөх тохиолдолд - хоногийн өмнө Зээлдэгчид Гэрээнд заасан цахим шуудангийн хаягт и-мэйл, гар утасны дугаарт зурвас илгээж, эсхүл Банк өөрийн цахим хуудас /www.xacbank.mn/, Монголбанкны албан ёсны цахим хуудаст мэдээлэл нийтлэгдсэнээр түүнд мэдэгдсэнд тооцно.

2.15. Банк хүү өөрчлөгдөх нөхцөл байдал үүссэн талаарх баримтыг зээлийн хувийн хэрэгт хавсаргаж, тус өдрөөс хойш ажлын 5 өдрийн дотор хүүгийн хувь хэмжээг өөрчлөнө. Зээлийн хүү өөрчлөгдсөнтэй холбогдуулан зээлийн данс өөрчлөгдөх бол өөрчлөгдсөн дансыг Зээлдэгчид 2.14-т заасны дагуу мэдэгдэнэ.

ГУРАВ. ЗЭЭЛИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТ

3.1. Зээлдэгч зээлийг үүрэг хүлээсний шимтгэл болон хүүгийн хамт 2.8-д заасан дансанд шилжүүлснээр эсхүл Банкны салбарт бэлнээр авчирч тушааснаар зээлийг эргэн төлсөнд тооцно.

3.2. Хавсралт 1-д заасан зээлийн төлбөр төлөх үүрэг нь Гэрээний хэсэгчилсэн үүрэг, уг үүргийг гүйцэтгэхээр заасан хугацаа нь хэсэгчилсэн үүргийг гүйцэтгэвэл зохих Гэрээний хэсэгчилсэн төлөх хугацаа гэж тооцогдоно. Заасан хугацаанд хэсэгчилсэн үүргийг зохих ёсоор гүйцэтгээгүй нь Зээлийн гэрээний үүргийн зөрчилд тооцогдож, Гэрээний 2.6-д заасны дагуу нэмэгдүүлсэн хүү тооцох үндэслэлд хамаарна.

3.3. Хавсралт 1-д зээлийг Гэрээний хугацааны эцэст төлөхөөр заасан нөхцөлд энэ гэрээний 3.2 дахь хэсэг хамаарахгүй буюу хэсэгчилсэн хугацаа, хэсэгчилсэн үүргийн зөрчил тооцогдохгүй.

3.4. Зээлдэгч нь зээлийн төлбөрийн үүргийг 2.1-т заасан авсан валютын төрлөөр буцаан төлнө.

3.5. Хэрвээ Зээлдэгч төгрөгөөс бусад валютаар олгосон зээлийг төгрөгөөр төлөх, эсхүл төгрөгөөр авсан зээлийг бусад валютаар төлөх тохиолдолд Банк гадаад валют худалдах, худалдан авах үйлчилгээг Банкны тухайн өдрийн бэлэн болон бэлэн бус валют арилжааны ханшаар тооцож үзүүлнэ. Ийнхүү үзүүлсэн валют арилжааны үйлчилгээ нь Зээлийн харилцаанд үл хамаарна.

3.6. Зээлдэгч ашигласан зээлийг үндсэн болон хэсэгчлэн төлөх хугацаанаас өмнө бүхэлд нь болон хэсэгчлэн төлж, уг дүнгээр зээлийн эрхийн хэмжээ эргэн нэмэгдэх нь энэхүү Гэрээний гол онцлог бөгөөд тухайн дансанд төлбөр хийх үе хүртэл бодогдсон үүрэг хүлээсний шимтгэл, нэмэгдүүлсэн хүү, хүүгийн төлбөрийг эхний ээлжинд, үлдэх дүнг ашигласан зээлийн үндсэн төлбөрт тооцно.

3.7. Зээлийг төлбөр гүйцэтгэх буюу үндсэн болон хэсэгчлэн төлөх хугацаанаас хожимдуулан эсхүл дутуу төлвөл уг дүнгээс тухайн төлбөр хийх хүртэл хуримтлагдан тооцогдсон үүрэг хүлээсний шимтгэл, нэмэгдүүлсэн хүү, хүүг төлүүлж үлдэх дүнг үндсэн төлбөрт тооцно.

3.8. Зээлдэгч нь зээл, түүний хүү (үндсэн болон хэтэрсэн хугацааны) болон нэмэгдүүлсэн хүүг Гэрээний 2.2-т заасан хугацаа дуусан эсэхээс үл хамааран Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 20.3-т заасны дагуу төлнө.

3.9. Зээлдэгч Гэрээний үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд зээлийн төлбөрийг Зээлдэгч, Хамтран үүрэг гүйцэтгэгч болон Батлан даагчийн Банк дахь **5001591175, 5003989869** дугаар харилцах данс болон бусад бүх данс, Худалдаа хөгжлийн банк дахь **499184240, 499181239,** дугаар данс, Голомт банк дахь **1505004958, 1505007301, 1505007268** дугаар данс, Хаан банк дахь **5038018577, 5007188182, 5038031166** дугаар данс, Төрийн банк дахь **34652273765, 109000013039, 346502273779** дугаар данс, Хөгжлийн банк дахь **3600000771** дугаар данс болон бусад бүх данс болон энэхүү Гэрээ байгуулснаас хойшхи хугацаанд шинээр нээлгэсэн аливаа дансууд дахь мөнгөн хөрөнгөөс болон уг дансдад орох орлогоос зээлийн шугамыг төлөх нөхцөл (Хавсралт 1)-ийн дагуу үл маргах журмаар төлбөр гүйцэтгүүлэхийг энэхүү Гэрээний дагуу зөвшөөрч үүгээр төлбөрийн даалгавар өгч байгаа болно.

ДӨРӨВ. ЗЭЭЛДЭГЧИЙН ЗӨВШӨӨРӨЛ БА БАТАЛГАА

4.1. Зээлдэгч болон Хамтран үүрэг гүйцэтгэгч нар нь Зээлийн шугамын гэрээ байгуулсантай холбогдуулан дараах зөвшөөрлийг Банкинд олгосон бөгөөд дахин бичгээр зөвшөөрөл олгох, авах шаардлагагүй болно.

4.1.1 Гэрээний үүргээ хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд 3.9-т заасан дансны мөнгөн хөрөнгөөс болон уг дансанд орох орлогоос зээлийн төлбөр, бусад төлбөрийг үл маргах журмаар суутган авах;

4.1.2. Зээлдэгчийн "Дебит гүйлгээний зөвшөөрлийн маягт"-ын дагуу өгсөн зөвшөөрлийг үндэслэн түүний бусад Банк дахь данснаас зээлийн төлбөр болон бусад төлбөрийг үл маргах журмаар суутган авах;

4.1.3. Зээлийн мэдээллийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан өөрт холбогдох зээлийн мэдээллийг Монголбанк болон зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч этгээдэд өгөх;

4.1.4. Зээлийн шугамын гэрээний үүрэг дуусгавар болох хүртэлх хугацаанд Зээлдэгч, Хамтран үүрэг гүйцэтгэгчийн талаарх аливаа мэдээлэл, лавлагааг Улсын бүртгэлийн болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, бусад холбогдох байгууллагаас авах;

4.1.5. Батлан даагчийн шаардлагаар Зээлдэгчийн хүлээсэн үүрэг түүний биелэлтийн мэдээлэл, зээлийн дансны хуулгыг түүнд гаргаж өгөх;

4.1.6. Даатгалын компаниас 100,000 төгрөг болон түүнээс дээш нөхөн төлбөр олгохтой холбоотой мэдээллийг авах;

4.1.7. Энэхүү гэрээний 3.9, 5.6.9-д заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд өөрт холбогдох зээлийн мэдээллийг задруулах.

4.2. Зээлдэгч нь энэхүү Гэрээг байгуулахдаа дараах баталгааг гаргасан ба Гэрээний хугацаанд баталгаа зөрчигдөх нь Зээлийг хугацаанаас өмнө буцаан шаардах үндэслэл болно. Үүнд:

4.2.1. Зээлдэгч нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан хуулийн этгээд мөн бөгөөд энэхүү Гэрээг байгуулахад шаардагдах бүх эрх, итгэмжлэл болон зөвшөөрлийг авсан болохыг;

4.2.2. Зээл авахтай холбогдуулан Банкинд хүргүүлсэн мэдээлэл, танилцуулга нь үнэн зөв бөгөөд санхүүгийн тайлан, мэдээлэлдээ гуравдагч талд төлөх бүх өр, төлбөр, үүргээ бүрэн тусгасан ба эдгээр санхүүгийн тайлан, мэдээлэл нь Зээлдэгчийн санхүүгийн байдлыг үнэн зөв харуулж байгаа болно. Банкинд мэдэгдээгүй аливаа өр, төлбөр, үүрэг, тэдгээртэй холбоотой аливаа маргаан, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, үүрэг, хариуцлага байхгүй болохыг;

4.2.3. Татварын болон нийгмийн даатгалын аливаа өр төлбөргүй, ийм төрлийн үүргийг цаг тухайд нь зохих ёсоор төлөхийг;

4.2.4. Зээлдэгчийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд хохирол учруулсан бол энэ тухай Банкинд даруй мэдэгдэж, хохирлыг Зээлдэгч холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцахыг.

ТАВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

5.1. Зээлдэгч дараах эрхтэй:

5.1.1. Зээлийг зориулалтын дагуу Гэрээнд заасан хугацаагаар ашиглах;

5.1.2. Өөрийн зээлийн шугамын дансны хуулга, зээлийн үндсэн төлбөр, үүрэг хүлээсний шимтгэл болон хүүгийн тооцоолол зэрэг холбогдох мэдээллийг Банкнаас авах;

5.1.3. Гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлсэн нөхцөлд Банкны зээлийн журмын дагуу дахин зээл авах, бусад урамшуулалд хамрагдах;

5.1.4. Зээлийн шугамын гэрээний хугацааг сунгах, Хавсралт 1-ийн дагуу тохирсон зээлийн шугамыг төлөх нөхцлийг өөрчлөх хүсэлтээ 30-аас доошгүй хоногийн өмнө бичгээр гаргах;

5.1.5. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл тохиолдсоны улмаас зээлийн эргэн төлөлтийг хэвийн төлөх боломжгүй болсон тохиолдолд Зээлдэгч уг нөхцөл байдлаа нотлох замаар зээлийн нөхцлийг өөрчлүүлэх хүсэлт тавих;

5.1.6. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Банкнаас шаардах болон хуульд заасан бусад.

5.2. Зээлдэгч болон Хамтран үүрэг гүйцэтгэгч нар нь дараах үүрэгтэй:

5.2.1. Зээлийг гэрээгээр тохирсны хүрээнд зориулалтын дагуу ашиглаж, зээл, хүү, үүрэг хүлээсний шимтгэл, тооцогдсон бол нэмэгдүүлсэн хүүгийн хамт буцаан төлөх;

5.2.2. Зээлийн ашиглалт, зарцуулалтад хяналт тавих боломж, нөхцлөөр Банкийг хангаж, шаардлагатай мэдээ, мэдээллийг гаргаж өгөх;

5.2.3. Хуулийн этгээдийн хувьд болон бизнесийн үйл ажиллагаагаа явуулах холбогдох шаардлагыг бүрэн хангаж, зөвшөөрөл түүнтэй адилтгах баримт бичгийг хуулийн дагуу авч, Гэрээний үүрэг бүрэн биелэгдэх хугацаанд шаардлагыг хангаж, хугацааг сунгуулж, хүчин төгөлдөр байдлыг хангах;

5.2.4. Нийгэм, байгаль орчны холбогдолтой болон Мөнгө угаах, терроризмийг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, стандартуудад нийцүүлэн холбогдох журмуудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж, нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу хөтлөх;

5.2.5. Зээлийн ашиглалт, үйл ажиллагааны тухай дараахь тайлан, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд эсхүл тухай бүр Банкинд ирүүлэх:

5.2.5.1. Зээлийн ашиглалтын талаарх мэдээллийг зээл олгосноос хойш 1 сарын дотор;

5.2.5.2. Санхүүгийн тайлан (тайлан тэнцэл, орлого үр дүн, өмчийн өөрчлөлтийн болон мөнгөн гүйлгээний тайлан)-г дараа улиралын эхний 1 сарын дотор;

5.2.5.3. Санхүүгийн жилийн эцсийн тайланг хөндлөнгийн аудитын байгууллагаар аудитлуулан дараа жилийн эхний 4 сарын дотор;

5.2.5.4. Банкнаас шаардсан бусад тайлан мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд;

5.2.5.5. Дүрэм, гэрчилгээний өөрчлөлтийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг өөрчлөлт орсон тухай бүр.

5.2.6. Зээлдэгч, Хамтран үүрэг гүйцэтгэгч, Батлан даагчийн үйл ажиллагаа, удирдлага, зохион байгуулалтад орсон дараахь өөрчлөлтүүдийг Банкинд ажлын 15 өдрийн дотор бичгээр мэдэгдэнэ:

5.2.6.1. Зээлдэгч болон Батлан даагч, тэдгээрийн өмчлөгч, гүйцэтгэх удирдлагын нэр, хуулийн этгээдийн нэр, гүйцэтгэх захирал, санхүүгийн албаны даргын оршин суух хаяг, холбоо барих утасны дугаарт өөрчлөлт орсон, оршин байх\суух хаяг тогтмол өөрчлөгдөх, явуулын байдлаар бизнес эрхлэх болсон зэрэг нөхцөлд;

5.2.6.2. Харилцагч банкаа өөрчилсөн, харилцах данс нээлгэсэн бол;

5.2.6.3. Барьцаа хөрөнгө болон бизнесийн үйл ажиллагаатай холбогдох санхүү, эдийн засгийн үр дагавар, үүрэг үүсгэх аливаа асуудал үүссэн буюу гуравдагч этгээдийн зүгээс шаардлага үүсгэсэн бол.

5.2.7. Зээлдэгч, Хамтран үүрэг гүйцэтгэгч нь дараах шийдвэрийг гаргахдаа Банкинд урьдчилан бичгээр мэдэгдэж, зөвшөөрөл авах:

5.2.7.1. Бизнесийн үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөх;

5.2.7.2. Бусад банк, санхүүгийн байгууллагаас зээл авах;

5.2.7.3. Гуравдагч этгээдэд баталгаа, батлан даалт гаргах;

5.2.7.4. Хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах;

5.2.7.5. Ногдол ашиг хуваарилах;

5.2.7.6. Зээлдэгч нь зээлийн хугацаанд томоохон хөрөнгө оруулалтын зардал гаргах.

5.2.8. Энэхүү Гэрээгээр эдлэх эрх, хүлээсэн үүргээ Банкны бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй байх;

5.2.9. Зээлийн зориулалт, эргэн төлөгдөх эх үүсвэр болон бизнес, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны онцлогт уялдуулан аюулгүй, эрүүл ахуйн, техникийн, бусад холбогдох шаардлагыг хангаж, эрсдэлтэй хэсэгт даатгуулах зэргээр өөрийн үйл ажиллагааны найдвартай байдлыг бүрдүүлэх;

5.2.10. Хамтран үүрэг гүйцэтгэгч нь Зээлдэгчийн энэ Гэрээний дагуу хүлээсэн үүргийг хамтран гүйцэтгэнэ;

5.2.11. Энэхүү Гэрээг байгуулахтай холбогдуулан олж авсан буюу мэдсэн Банкны бизнесийн үйл ажиллагааны аливаа мэдээллийг шууд буюу шууд бус замаар гуравдагч этгээдэд тараахгүй байх, өөрийн болон бусдын ашиг сонирхолд нийцүүлэн Банкинд хохирол учруулах зорилгоор ашиглахгүй байх;

5.2.12. Хамтран үүрэг гүйцэтгэгч нь Зээлдэгчийн үүргийн гүйцэтгэлийн явц, түүний төлбөрийн чадвар зэрэг болон өөрт нь ногдож болзошгүй үүргийн талаар өөрт шаардлагатай гэж үзсэн бүхий л асуудалд хяналт тавьж, зохих мэдээллийг өөрөө олж авах, мөн зээлдэгчээс үүргээ биелүүлэхийг шаардах үүрэгтэй.

5.2.13. Амьдран суух хаяг, гар утасны дугаар, цахим шуудангийн хаяг, орлогын эх үүсвэрт өөрчлөлт орсон болон санхүү, эдийн засгийн үр дагавар, үүрэг үүсгэх хүчин зүйлийн талаар, хөдөлмөр эрхлэлтэд орсон өөрчлөлтөө тухай бүр Банкинд мэдэгдэж, өөртэйгөө холбоотой мэдээллийг шинэчлүүлж байх;

5.2.14. 2 жил тутам бүрэн, эсхүл санхүүгийн үйлчилгээ авах тухай бүр Банкинд мэдэгдэж өөрийн Зээлдэгчийн мэдээллээ баталгаажуулах болон шинэчлэгүйн улмаас Банк болон Зээлдэгчид учирсан аливаа хохирлыг Зээлдэгч бүрэн хариуцна;

5.2.15. Хууль, тогтоомж болон Гэрээнд заасан бусад.

5.3. Хамтран үүрэг гүйцэтгэгч нь зээлийн эцсийн үлдэгдлийн талаар Банкнаас мэдээлэл авах эрхтэй.

5.4. Хамтран үүрэг гүйцэтгэгч нь Зээлдэгчтэй адил (5.1.1, 5.1.3, 5.1.5-д зааснаас бусад) эрхтэй байна.

5.5. Зээлдэгч, Хамтран үүрэг гүйцэтгэгч нь Гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчвөл Гэрээнээс татгалзах эрхээ алдана.

5.6. Банк дараах эрхтэй:

5.6.1. Зээлдэгчээс зээл, үүрэг хүлээсний шимтгэл, хүү болон нэмэгдүүлсэн хүү, энэхүү Гэрээний 6.3-т заасан төлбөрийг төлөхийг шаардах;

5.6.2. Зээлдэгч, Хамтран үүрэг гүйцэтгэгчээс зээлийн зориулалтын дагуу бий болсон аливаа хөрөнгө, зээл төлөх орлогын эх үүсвэр, тэдгээрийн өөрчлөлт, барьцааны зүйлийг даатгуулахыг шаардах;

5.6.3. Банкинд ирүүлэх тайлан мэдээг 3 ба түүнээс дээш удаа ирүүлээгүй, ирүүлсэн тайлан, санхүүгийн мэдээ нь бодит байдалтай нийцээгүй, Банкнаас хамтын ажиллагааг сайжруулах талаар өгсөн үүрэг даалгавар, шаардлагыг тогтоосон хугацаанд биелүүлээгүй, Зээлдэгчийн борлуулалт, үйлдвэрлэлийн хэмжээ төлөвлөснөөс 30 буюу түүнээс дээш хувиар буурсан, түүнчлэн энэхүү Гэрээний 7.2.1-7.2.3, 7.2.7-д заасан нөхцөл байдлууд нь Зээлдэгчийн бизнесийн үйл ажиллагааны хэвийн байдалд нөлөөлөхгүй гэж Банк үзсэн нөхцөлд Зээлдэгчийн үндсэн болон эргэлтийн хөрөнгө, бизнесийн үйл ажиллагаа, санхүүгийн анхан шатны бүртгэл хөтлөлтийг

шалгах, үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн болон санхүү бүртгэл, удирдлага, барьцаа хөрөнгийн талаар шаардлагатай арга хэмжээ авахыг шаардах;

5.6.4. Энэхүү Гэрээний 5.6.3-т заасан нөхцөл байдал үүссэн бол түүнд нийцүүлэн Банкны санаачилгаар Зээлийн шугамыг төлөх нөхцөл (Хавсралт 1)-ийг шинэчлэн тогтоох эсхүл нөхцөл байдал сайжиртал дараагийн санхүүжилт, шугамын эрхийг түр зогсоож энэ талаар Зээлдэгчид мэдэгдэх;

5.6.5. Гэрээний хугацаанд барьцаа хөрөнгийн зах зээлийн үнэлгээ буурсан, чанар байдал дордсон, устаж үгүй болсон болон 2.10-т заасан үүргийн гүйцэтгэлийг хангах арга хэрэгжих боломжгүй нөхцөл үүсвэл Банк хөрөнгийг дахин үнэлэх, шаардлага хангахуйц хөрөнгийг нэмж барьцаалуулах, үүргийн гүйцэтгэлийг хангах өөр аргыг зохих ёсоор нэмэхийг шаардах;

5.6.6. Зээлдэгч Гэрээний үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол үүргийн гүйцэтгэлийг Зээлдэгч болон Хамтран үүрэг гүйцэтгэгчийн хэнээс нь ч бүхэлд нь буюу хэсэгчлэн шаардах;

5.6.7. Зээлдэгч, Хамтран үүрэг гүйцэтгэгчийн зөвшөөрөлгүйгээр Гэрээний шаардах эрхээ гуравдагч этгээдэд шилжүүлэх (зээлийг худалдах);

5.6.8. Хуульд өөрөөр заагаагүй бол Гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангах аргыг хэрэгжүүлэх дараалыг тогтоох;

5.6.9. Зээлийн шугамын болон 2.10-т заасан Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхээс санаатайгаар зайлсхийсэн, Банкны шаардах эрхээ хэрэгжүүлэх боломж хязгаарлагдсан тохиолдолд Зээлдэгчээс Гэрээний үүргээ биелүүлэхийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан шаардах;

5.6.10. Банк нь Зээлдэгчийн мэдээллийг шинэчлэх зорилгоор түүний амьдран суух хаяг, гар утасны дугаар, цахим шуудангийн хаяг, орлогын эх үүсвэрт өөрчлөлт орсон болон санхүү, эдийн засгийн үр дагавар, үүрэг үүсгэх хүчин зүйлийн талаар, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой мэдээллийг Зээлдэгчээс шаардаж авах эрхтэй;

5.6.11. Банк нь 2 жил тутам бүрэн, эсхүл санхүүгийн үйлчилгээ авах тухай бүр Зээлдэгчийн мэдээллийг шинэчлэн авахаар шаардах эрхтэй бөгөөд ийнхүү шаардахад Зээлдэгч мэдээллээ баталгаажуулах болон шинэчлээгүйн улмаас Банк болон Зээлдэгчид учирсан аливаа хохиролыг Банк хариуцахгүй болно;

5.6.12. Хууль, тогтоомж болон Гэрээнд заасан бусад эрх.

5.7. Банк дараах үүрэгтэй:

5.7.1. Гэрээгээр тохирсон нөхцөл биелсэн, 2.10-т заасан гэрээнүүд хүчин төгөлдөр болсноор зээлийн эрхийг гэрээнд заасны дагуу нээх;

5.7.2. Зээлийн шугамын данснаас зарлагын гүйлгээ хийлгэхээр Зээлдэгч хүсэлт гаргасан даруй Гэрээний 2.13-т болон бусад хэсэгт заасан татгалзах нөхцөл байдал бүрдээгүй бол холбогдох гүйлгээг хийх;

5.7.3. Зээлтэй холбоотой аливаа төлбөр, тооцоо, бүртгэлийг үнэн зөв гүйцэтгэж, Гэрээний харилцаанд хамаарах хүү, шимтгэлийн талаарх мэдээлэл болон Зээлдэгчийн хүсэлтээр зээлийн дансны хуулгыг өгч, Зээлдэгчийн нууцыг задруулахгүй байх;

5.7.4. Батлан даагч шаардсан тохиолдолд Банк нь Зээлдэгчийн хүлээсэн үүрэг түүний биелэлтийн мэдээлэл, зээлийн дансны хуулгыг Батлан даагчид өгөх;

5.7.5. Зээлдэгч 5.1.5-т заасан үндэслэлээр зээлийн нөхцөл өөрчлүүлэх хүсэлт гаргасан тохиолдолд хүсэлтийг хүлээн авч зээлийн нөхцөл өөрчлөх эсэх шийдвэр гаргах;

5.7.6. Хууль, тогтоомж болон гэрээнд заасан бусад.

ЗУРГАА. ХАРИУЦЛАГА

6.1. Зээлдэгч нь Гэрээний хугацаа дуусгавар болох үед ашигласан зээлийн үлдэгдэлтэй байх тохиолдолд тухайн ашигласан зээлийн үлдэгдлээс, түүнчлэн ашигласан зээлийн үлдэгдэл нь Хавсралт 1-т заасан зээлийн шугамын эрхийн хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд хэтэрсэн дүнгээс 2.6-т заасны дагуу нэмэгдүүлсэн хүү тооцно.

6.2. Гэрээний хугацаа дуусгавар болсон нь Зээлдэгч, Хамтран үүрэг гүйцэтгэгчийг үндсэн зээл, 2.3-т заасан хүү (үндсэн болон хэтэрсэн хугацааны) 2.4-т заасан үүрэг хүлээсний шимтгэл болон 2.6-д заасан нэмэгдүүлсэн хүүгийн төлбөр төлөх үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

6.3. Талуудын аль нь Гэрээний үүргээ зөрчсөнөөс үүссэн буюу барьцааны зүйлийг арчлан хамгаалах, худалдан борлуулахтай холбогдон гарсан зардал болон Зээлийн гэрээний үүргийг хангуулахтай холбогдон нөгөө талаас гарсан зардал, учирсан хохирлыг зөрчил гаргасан тал хариуцна.

6.4. Зээлдэгч энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн, 7-р зүйлд заасан нөхцөл байдал үүссэн болон бусад байдлаар уг Гэрээний үүргийн гүйцэтгэлд сөргөөр нөлөөлөхүйц аливаа нөхцөл байдал үүссэн тохиолдолд Банк 3.9-д заасан болон Зээлдэгчийн бусад данснаас үл маргах журмаар зээлийн төлбөрийг төлүүлнэ.

6.5. Зээлдэгч, Хамтран үүрэг гүйцэтгэгч нь Гэрээний хавсралт Нэмэлт нөхцөлд заасан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд уг зөрчил үүссэн өдрөөс эхлэн 2.3-т заасан хүүгийн хэмжээг - хувь болгохоор талууд тохиролцсон болно.

ДОЛОО. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ, ХУГАЦААНААС ӨМНӨ ЗЭЭЛИЙГ БУЦААН ШААРДАХ НӨХЦӨЛ

7.1. Энэхүү Гэрээний хугацаа дуусах үед ашигласан зээлийг хүү, үүрэг хүлээсний шимтгэл, тооцогдсон бол нэмэгдүүлсэн хүүгийн хамт бүрэн төлөгдөж үүрэг зохих ёсоор биелэгдсэн, эдгээр төлбөр бүрэн төлөгдөж дуусснаар энэхүү Гэрээ дуусгавар болно.

7.2. Дараахь нөхцөлд Зээлдэгч Гэрээнээс татгалзах эрхээ алдан, Банк санаачлан хугацаанаас өмнө ашигласан зээлийг эргүүлэн шаардаж эрхийн хэмжээг бууруулна:

7.2.1. Зээлдэгч энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй;

7.2.2. Энэхүү Гэрээний 4.2-д заасныг зөрчсөн, зээл авахдаа худал мэдээлэл өгсөн, хуурамч баримт бичиг бүрдүүлсэн;

7.2.3. Зээлийг зориулалтын дагуу ашиглаагүй, эсхүл зээлийг анх авахдаа зориулалтын дагуу ашигласан боловч зээлийн хугацаанд зээлийн санхүүжилтээр бий болсон эргэлтийн хөрөнгөөр үндсэн хөрөнгө худалдан авах, хөрөнгө оруулалт хийх, гуравдагч этгээдийн өр төлбөрийг төлөх зэргээр зориулалт бусаар ашигласан, түүнчлэн эргэлтийн хөрөнгийн хэмжээ нь бизнесийн үйл ажиллагаатай хамааралгүйгээр материаллаг дүнгээр буурсан;

7.2.4. Зээлдэгчийн бизнесийн үйл ажиллагаа зогссон;

МОНГОЛ УЛС

7.2.5. Эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлсэн, цуцалсан, хүчингүй болгосон нь бизнесийн үйл ажиллагааг хэвийн явуулахад саад учруулж, зээлийн төлбөрийн үүрэг гүйцэтгэхэд хүндрэл учирч эхэлсэн;

7.2.6. Зээлийг төлөх төлбөрийн чадваргүй болсон, дампуурах, татан буугдах нөхцөл байдал үүссэн;

7.2.7. Зээлдэгчийн бизнесийн болон удирдлага зохион байгуулалтын хэвийн үйл ажиллагаа алдагдсан, эсхүл бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт орсны улмаас Гэрээний үүргийн биелэлтэд нөлөөлөхүйц эрсдэлтэй болсон;

7.2.8. Зээлдэгч хууль бус үйл ажиллагаа явуулсан болохыг эрх бүхий байгууллага тогтоосон;

7.2.9. Зээлдэгчийн өмч хөрөнгө болон түүнд санхүүгийн үүрэг ногдуулах асуудлаар нийт хөрөнгийн 10 болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний дүнгээр бусад этгээд маргаан, эрүүгийн хэрэг үүсгэж, Зээлдэгч буруутай болох нь тогтоогдсон;

7.2.10. Барьцаа хөрөнгөөр зээлийг хаахад хүрэлцэхгүй нь тодорхой болсон, эсвэл барьцаа хөрөнгийн зах зээлийн үнэлгээ буурсан нөхцөлд нэмж өөр хөрөнгө барьцаалуулахаас татгалзсан;

7.2.11. Зээлдэгч энэхүү Гэрээ, хавсралтын дагуу төлбөр гүйцэтгэх үүргээ зөрчих, зөрчилийг арилгахгүй байх тохиолдолд;

7.2.12. Гэрээний харилцааг хэвийн үргэлжлүүлэх боломжгүй болсон, Банк шаардлагатай гэж үзсэн бусад тохиолдолд;

7.2.13. Барьцааны гэрээ, Ипотекийн гэрээ, Батлан даалтын гэрээ, Фидуцийн гэрээгээр хүлээсэн аливаа үүрэг, баталгаа, тэдгээрийн зүйл заалтыг зөрчсөн.

7.3. Зээлдэгч, Хамтран үүрэг гүйцэтгэгч Гэрээний 7.2-т заасан Банкны шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд Банк 2.10-т заасан үүргийн гүйцэтгэлийг хангах аргыг хэрэгжүүлнэ.

7.4. Зээлдэгч хуулийн этгээд нь татан буугдах болон аливаа хэлбэрээр өөрчлөн зохион байгуулагдах тохиолдолд түүний эрх, үүрэг шинээр бий болсон эрх залгамжлагчид албан ёсоор шилжсэнд тооцох бөгөөд, хэрвээ эрх залгамжлагч байхгүй тохиолдолд 2.10-т заасан үүргийн гүйцэтгэлийг хангах аргыг хэрэгжүүлж төлбөр барагдуулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

7.5. Банк энэхүү Гэрээнд заасан эрхээ хэрэгжүүлээгүй буюу хугацаанд нь хэрэгжүүлээгүй нь энэхүү эрхээ хэрэгжүүлэхээс татгалзсан гэж үзэх үндэслэл болохгүй.

7.6. Энэхүү Гэрээний үүрэг нь Зээлдэгч, Хамтран үүрэг гүйцэтгэгчийн хувийн байдал (зээлийг эргэн төлөх санхүүгийн боломж нь судалгаагаар батлагдсан)-тай салшгүй холбоотой бөгөөд Зээлдэгч нас барсан гэж зарлагдсан, нас барсан нөхцөлд түүний өв залгамжлагчид нь зээлийн төлбөрийг хуваарийн дагуу хэсэгчлэн буюу бүрэн төлөх боломжтой бөгөөд хүсэлт гаргасан бол Банк тохиролцон Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж Гэрээний эрх, үүргийг шилжүүлнэ. Харин өв залгамжлагч нь зээлийн төлбөрийг барагдуулах, Гэрээний эрх, үүргийг шилжүүлэн авах талаар Банктай тохиролцоогүй, эсхүл хүсэлт гаргасан боловч зээлийн төлбөрийг хэсэгчлэн болон бүрэн төлөх орлогын эх үүсвэргүй нөхцөлд энэхүү Гэрээг дуусгавар болсонд тооцож, Банк холбогдох хуулийн дагуу 2.10-т заасан үүргийн гүйцэтгэлийг хангах аргыг хэрэгжүүлнэ. Мөн Зээлдэгч сураггүй алга болсонд тооцогдсон нөхцөлд энэхүү Гэрээ дуусгавар болж тус Гэрээний үүргийг Иргэний хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т заасны дагуу Зээлдэгчийн эд хөрөнгөөс гүйцэтгүүлнэ.

НАЙМ. БУСАД

8.1. Энэхүү Гэрээнд талууд гарын үсэг зурж, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.

8.2. Энэхүү Гэрээг **3** хувь үйлдэх ба хувь тус бүр хууль зүйн адил хүчинтэй байна.

8.3. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг талууд харилцан тохиролцож шийдвэрлэх ба аливаа нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэнэ. Энэхүү Гэрээний хавсралтууд болон нэмэлт нөхцөл, нэмэлт, өөрчлөлт нь Гэрээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг байна.

8.4. Гэрээтэй холбоотой аливаа маргаантай асуудлыг талууд хоорондоо зөвшилцөх, харилцан тохиролцож шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд тохиролцоонд хүрч чадахгүй бол Монгол Улсын хуулийн дагуу Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ХасБанкийг төлөөлж:
Байгууллагын Банк
Хариуцсан захирал

Б.ЕРКИН

Зээлдэгчийг төлөөлж:
Эрдэнэс Монгол ХХК-ийн
Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч

О.ХҮЛАН

25 FEB 2022
.... он ... сар ... өдөр Бүртгэлийн № 3/2
Нийслэлийн тойргийн нотариатч
Х.Энхбаатар би энэхүү үйлдлийн
үнэн зөвийг гэрчлэв
Нотариатч .....

2022 оны **ЗГ5004912848** дугаартай
Зээлийн шугамын гэрээний **Хавсралт 1**

ЗЭЭЛИЙН ШУГАМЫГ ТӨЛӨХ НӨХЦӨЛ

Зээл олголтын шимтгэл **3,000,000** төгрөг

№	Зээлийн шугамыг төлөх огноо	Зээлийн шугамын эрхийн хэмжээ / Төгрөг/	
		Тоогоор	Үсгээр
1	2022/02/24	3,000,000,000	(Гурван тэрбум)
2	2022/11/24	0	(Тэг)

Зээлийн шугамыг төлөх нөхцөлийг хүлээн зөвшөөрсөн:

ХасБанкийг төлөөлж:
Байгууллагын Банк
Хариуцсан захирал

Б.ЕРКИН

Зээлдэгчийг төлөөлж:
Эрдэнэс Монгол ХХК-ийн
Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч

О.ХҮЛАН

ХАСБАНК

2022 ОНЫ **ЗГ5004912848** ДУГААРТАЙ ЗЭЭЛИЙН ШУГАМЫН ГЭРЭЭНИЙ НЭМЭЛТ НӨХЦӨЛ

2022 оны **02** дугаар сарын **24**-ний өдөр Улаанбаатар хот

Нэг талаас **ХасБанк** (улсын бүртгэлийн дугаар: **9016001007**, регистрийн дугаар: **2578697**) /цаашид "Банк" гэх/, нөгөө талаас Зээлдэгч **ЭРДЭНЭС МОНГОЛ ХХК** (улсын бүртгэлийн дугаар: **9011014002**, регистрийн дугаар: **5124913**) /цаашид "Зээлдэгч" гэх/ нарын хооронд **2022** оны **02** дугаар сарын **24**-ний өдөр байгуулсан **ЗГ5004912848** дугаартай Зээлийн шугамын гэрээ /цаашид хамтад нь "Үндсэн гэрээ" гэх/-нд талууд харилцан тохиролцож, дараах нэмэлт нөхцөлийг байгуулав.

НЭГ. НЭМЭЛТ НӨХЦӨЛ

1.1 Зээлдэгч нь борлуулалтын орлогын 50-аас доошгүй хувийг Банк дахь өөрийн харилцах хадгаламжийн дансаар дамжуулна.

1.2 Зээлдэгч нь ирээдүйд байгуулагдах аливаа гэрээ, хэлцэлд Банк дахь өөрийн дансыг тусгаж, уг дансаар дамжуулан төлбөр хүлээн авах, төлбөр гүйцэтгэх үүрэг хүлээнэ.

1.3 Зээлдэгч нь зээлийн хугацаанд томоохон хөрөнгө оруулалтын зардал гаргах, бусад банк санхүүгийн байгууллагаас зээл авах, ногдол ашиг хуваарилах, аж ахуйн нэгжийн өмчлөл, бүтцэд өөрчлөлт орох тохиолдолд урьдчилан Банканд бичгээр мэдэгдэнэ.

ХОЁР. БУСАД НӨХЦӨЛ

2.1 Нэмэлт нөхцөл нь Үндсэн гэрээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг болно.

2.2 Зээлдэгч нь энэхүү нэмэлт нөхцөлийг зөрчсөн нь Үндсэн гэрээний үүрэг зөрчигдсөнд тооцох бөгөөд Банк Үндсэн гэрээнд заасан аливаа эрхийг хэрэгжүүлэх эрх үүссэнд тооцогдоно.

2.3 Нэмэлт нөхцөлд талууд гарын үсэг зурж, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.

НЭМЭЛТ, НӨХЦӨЛИЙГ БАЙГУУЛСАН:

ХасБанкийг төлөөлж:
Байгууллагын Банк
Хариуцсан захирал

Б.ЕРКИН

Зээлдэгчийг төлөөлж:
Эрдэнэс Монгол ХХК-ийн
Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч

О.ХҮЛАН

ЭРДЭНЭС МОНГОЛ
УЛААНБААТАР ХОТ
1119279716 № 5124913

МОНГОЛ УЛС
MONGOLIA
179

25 FEB 2022 сар, өдөр Бүртгэлийн № 312
Нийслэлийн тойргийн нотариатч
Х.Энхбаатар би энэхүү үйлдлийн
үнэн зөвийг гэрчлэв
Нотариатч .....

ГЭРЭЭНИЙ ТӨСӨЛ ХЯНАСАН АКТ

Огноо:	2022 оны 02 сарын 25
Гэрээний нэр:	Барьцааны гэрээ
Гэрээний дугаар:	ЭМГЛ- 01/БТ-01/20220225
Гэрээний товч утга:	Эргэлтийн хөрөнгийн зориулалтаар "Өмнөговь аймгийн Тавантолгой-Гашуунсухайт" чиглэлийн 239 км хатуу хучилттай автозамын зам ашиглалтын орлогыг барьцаалах тухай
Харилцагч иргэн, байгууллага:	Байгууллагын банк хариуцсан захирал Б.Еркин
Гэрээний төсөлд санал өгсөн мэргэжилтэн:	Хууль, дүрэм журмын хэрэгжилт хариуцсан хуулийн мэргэжилтэн Г.Гандуулга
Гэрээний хэрэгжилтийг хариуцах газар, мэргэжилтэн:	Санхүүгийн тайлагнал хариуцсан мэргэжилтэн Ү.Уранбилэг
Төсөв:	3,000,000,000 /гурван тэрбум төгрөг/

ХЯНАСАН, ТАНИЛЦСАН:

Албан тушаал/Овог нэр	Гарын үсэг	Огноо
Салбарын үйл ажиллагаа хариуцсан дэд захирал Л.Энхболд		2022. 02. 28
Захиргаа хариуцсан дэд захирал Ц.Цолмон		2022. 02.25
Хянан нийцүүлэлт хариуцсан хуулийн ахлах мэргэжилтэн Б.Болор		2022. 02. 25
Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогчийн түр орлон гүйцэтгэгч А.Мөнхтуяа		2022. 02. 25

ТӨСӨЛ БОЛОВСРУУЛСАН:

Хууль, дүрэм журмын хэрэгжилт хариуцсан хуулийн мэргэжилтэн Г.Гандуулга

ХАСБАНК

ХасБанк Маягт 01409

БАРЬЦААНЫ ГЭРЭЭ

2022 оны **02** дугаар сарын **24**-ний өдөр № **БГ5004912848-01** Улаанбаатар хот

Энэхүү Барьцааны гэрээ /цаашид "Гэрээ" гэх/-г нэг талаас Улаанбаатар хотын Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Ерөнхий Сайд Амарын гудамжны ХасБанкны төв байр хаягт оршин байх **ХасБанк** (улсын бүртгэлийн дугаар: **9016001007**, регистрийн дугаар: **2578697**) /цаашид "Банк", эсхүл "Барьцаалагч"гэх/, нөгөө талаас СБД, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө 15, 15-р давхар хаягт оршин байх Барьцаалуулагч **ЭРДЭНЭС МОНГОЛ ХХК** (улсын бүртгэлийн дугаар: **9011014002**, регистрийн дугаар: **5124913**) /цаашид "Барьцаалуулагч" гэх/ нар Иргэний хууль, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг баримтлан харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. ГОЛ НӨХЦӨЛ

1.1. Энэхүү Гэрээгээр Банк болон Зээлдэгч **ЭРДЭНЭС МОНГОЛ ХХК** нарын **2022** оны **02** дугаар сарын **24**-ний өдөр байгуулсан **ЗГ5004912848** дугаартай Зээлийн шугамын гэрээ /цаашид хамтад нь "Үндсэн гэрээ" гэх/-ний дагуу **Эргэлтийн хөрөнгийн** зориулалтаар, нийт **9** сарын хугацаатайгаар, жилийн буюу 365 хоногт тогтмол **14.4** хувийн хүүтэй, ашиглаагүй зээлийн эрхийн үлдэгдэлд жилийн буюу 365 хоногт **3** хувийн үүрэг хүлээсний шимтгэлтэйгээр авсан **3,000,000,000** (Гурван тэрбум) төгрөгийн зээлийн төлбөрийн үүргээ Зээлдэгч гүйцэтгээгүй, зохих ёсоор гүйцэтгээгүй тохиолдолд Барьцаалуулагч нь энэхүү Гэрээний 1.3-д заасан хөрөнгөөс үүргийн гүйцэтгэлийг энэ Гэрээ болон хуульд заасан журмын дагуу хангуулна.

1.2. Барьцаа хөрөнгөөр хангагдах шаардлагын хэмжээ нь Үндсэн гэрээгээр хүлээсэн үндсэн үүргийн хэмжээ, хүү, нэмэгдүүлсэн хүү, барьцааны хөрөнгийг худалдан борлуулахтай холбогдон гарсан зардал, улсын тэмдэгтийн хураамж, нөхөн төлүүлэх, шүүхийн зардал, барьцааны хөрөнгийг арчлан хамгаалахад гарсан зардал, уг эд хөрөнгөтэй холбоотойгоор төлсөн татвар, хураамж, төлбөр зэрэг барьцаалагчаас гарсан зардал, хохирлын хэмжээгээр тодорхойлогдоно.

1.3. Зээлдэгч Үндсэн гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй, зохих ёсоор гүйцэтгээгүй тохиолдолд Банкны шаардлагыг хангуулахаар Барьцаалуулагч **ЭРДЭНЭС МОНГОЛ ХХК**-ийн энэхүү Гэрээний **1** дүгээр хавсралтад заасан хөдлөх эд хөрөнгө болон эрхийг, түүний бүрдэл хэсэг, дагалдах зүйлийн хамт /цаашид "Барьцаа хөрөнгө" гэх/-аар тус тус барьцаалуулсан болно.

1.4. Тухайн барьцааны хөрөнгийн хувьд Барьцаалуулагчийн эрх нь Банкны эзэмшилд шилжүүлсэн /Цахим мэдээллийн санд бүртгүүлэх/, Мөнгөн хадгаламжийг Банкны хяналтад шилжүүлсэн (доогуур зурах)-ээр баталгаажсан бол Баталгаажсан барьцааны хөрөнгийг худалдсанаас олсон орлого нь шууд баталгаажсанд тооцно.

ХОЁР. БАТАЛГАА БА ЗӨВШӨӨРӨЛ

2.1. Барьцаалуулагч нь Гэрээ байгуулахтай холбогдуулан дараах баталгааг гаргаж Гэрээний хугацаанд баталгааг хангах бөгөөд шаардлагатай тохиолдолд Банкинд мэдэгдэнэ. Үүнд:

2.1.1. Барьцаа хөрөнгө нь Барьцаалуулагчийн хууль ёсны өмчлөлийн эд хөрөнгө мөн бөгөөд эрхийн болон биет байдлын доголдолгүй, Барьцаа хөрөнгөтэй холбоотой гуравдагч этгээдийн эд хөрөнгийн эрх байхгүй болно. Гуравдагч этгээдийн эд хөрөнгийн эрх байгаа бол: - эрх байна. Барьцаа хөрөнгийг Хамтран өмчлөгчдөөс тус Гэрээний - дүгээр хавсралт /ХасБанк Маягт 2009/-д заасны дагуу холбогдох зөвшөөрлийг авсан болно. Барьцаалуулагч нь уг мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцна;

2.1.2. Барьцаалуулагч нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан хуулийн этгээд мөн бөгөөд энэхүү Гэрээг байгуулахад шаардагдах бүх эрх, итгэмжлэл болон зөвшөөрлийг авсан болохыг үүгээр баталж байна;

2.1.3. Барьцаа хөрөнгийн эрх нь Барьцаалуулагчийн хууль ёсны эрх мөн бөгөөд Барьцаа хөрөнгө нь аливаа өр төлбөр, зардал, барьцаа, анз зэргээс чөлөөтэй байгаа болно.

2.2. Барьцаалуулагч нь Гэрээ байгуулсантай холбогдуулан дараах зөвшөөрлийг Банкинд олгосон бөгөөд дахин бичгээр олгох, авах шаардлагагүй болно. Үүнд:

2.2.1. Зээлийн мэдээллийн тухай хуулийн дагуу Үндсэн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангах аргатай холбоотой шаардагдах мэдээллийг МонголБанк болон зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч этгээдэд өгөх;

2.2.2. Үндсэн гэрээний үүрэг дуусгавар болох хүртэлх хугацаанд Барьцааны хөрөнгөтэй холбоотой болон Барьцаалуулагч /барьцаа хөрөнгийн өмчлөгч, эзэмшигч/-ийн талаарх аливаа мэдээлэл, лавлагааг Улсын бүртгэлийн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх болон бусад холбогдох байгууллагаас авах;

2.2.3. Барьцаа хөрөнгийн барьцааны үндсэн болон нэмэлт мэдэгдэл, тэмдэглэлийг Цахим мэдээллийн санд бүртгүүлэн баталгаажуулах;

2.2.4. Гэрээний үүрэг бүрэн биелэгдэх хүртэлх хугацаанд Барьцааны хөрөнгийг газар дээр нь шалгах, үүнд холбогдох баримт бичгийг гаргуулан авах эрхийг үүгээр олгож байна.

ГУРАВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Барьцаалагч нь Иргэний хууль, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуульд заасан Барьцаалагчийн эрх, үүргийг хүлээх бөгөөд дараах тухайлсан эрх, үүргийг хүлээнэ. Үүнд:

3.1.1. Хуульд заасны дагуу Барьцааны хөрөнгө, түүний ашиглалт, хадгалалт, арчилгаатай танилцах, холбогдох шаардлагыг Барьцаалуулагчид тавих, даатгалын тохиолдол үүссэн бол нөхөн төлбөрөөс тэргүүн ээлжинд зээлийн төлбөрийг төлүүлэх;

3.1.2. Барьцааны хөрөнгийн хадгалалт, ашиглалтын журам зөрчигдсөн, Барьцааны хөрөнгийн үнэ цэнэ буурах нөхцөл байдал үүссэн бол Барьцааны хөрөнгийг өөрийн эзэмшилд шилжүүлэх, шилжүүлэхийг шаардах;

3.1.3. Үндсэн гэрээний үүрэг зөрчигдсөн буюу зээлийн төлбөр зохих ёсоор төлөгдөөгүй үед шаардлагатай бол Барьцааны хөрөнгөөс олох орлого, үр шимээс зээлийг төлүүлэх, төлүүлэхийг шаардах эрх эдэлнэ;

3.1.4. Хуульд заасны дагуу Барьцаагаар хангагдах үүргийн гүйцэтгэлийг хангах арга, хөрөнгүүдээс төлбөр хангуулах дараалал болон хэмжээг тогтоох;

3.1.5. Гэрээний хугацаанд Барьцааны хөрөнгийн зах зээлийн үнэлгээ өссөн, буурсан бол Барьцаалуулагчийн эсхүл өөрийн санаачилгаар хөрөнгийг дахин үнэлж, зах зээлийн үнэлгээнд өөрчлөлт оруулах, үүнтэй холбогдуулан нэмэлт шаардлагыг Зээлдэгч, Барьцаалуулагчид тавих;

3.1.6. Гэрээний үүрэг бүрэн биелэгдэх хүртэл хугацаанд барьцаалагдсан Барьцааны хөрөнгийг газар дээр нь шалгах;

3.1.7. Барьцааны хөрөнгө нь Банк зөвшөөрснөөс бусад тохиолдолд барьцааны эрхтэйгээр гуравдагч этгээдэд шилжих ба Банк Барьцааны хөрөнгө эсхүл түүнийг захиран зарцуулснаас олсон орлогын аль хэрэгжих боломжтой хэсгээс үүргийг бүрэн хангуулах эрхтэй;

3.1.8. Хуульд болон Гэрээнд заасан бусад эрх үүрэг.

3.2. Барьцаалуулагч нь Иргэний хууль, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуульд заасан Барьцаалуулагчийн эрх, үүргийг хүлээх бөгөөд дараах тухайлсан эрх, үүргийг хүлээнэ. Үүнд:

3.2.1. Барьцааны гэрээний хугацаанд Барьцааны хөрөнгийг эзэмшилдээ байлгах ба бүрэн бүтэн байдлыг хангаж, засвар үйлчилгээг хариуцна. Уг үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас Барьцааны хөрөнгө Барьцаалагчийн эзэмшилд шилжсэн тохиолдолд холбогдон гарах зардлыг Барьцаалуулагч хариуцах;

3.2.2. Барьцааны хөрөнгийг Үндсэн гэрээний хугацаанд даатгуулах үүрэгтэй;

3.2.3. Гэрээний эрх, үүргийг Банкинд мэдэгдэж, бичгээр баталгаажуулахгүйгээр гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй байх үүрэгтэй;

3.2.4. Барьцааны хөрөнгийг худалдах, арилжих, бэлэглэх зэргээр бусдад шилжүүлэх бол түүний ургын овог, эцгийн нэр, нэр, регистрийн дугаар, утасны дугаар, оршин суух/байх хаяг, иргэний/хуулийн этгээдийн бичиг баримтын хуулбарын хамт Банкинд, тухайн Барьцааны хөрөнгөд барьцааны үүрэг ногдсон тухай шилжүүлэн авч буй этгээдэд тус тус мэдэгдэх үүрэгтэй;

3.2.5. Нийгэм байгаль орчны холбогдолтой болон Мөнгө угаах, терроризмийг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, журмуудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулах;

3.2.6. Барьцааны гэрээг нотариатаар гэрчлүүлэх, барьцааны эрхийг баталгаажуулах зэрэг зардал, хураамжийг хариуцах;

3.2.7. Барьцааны хөрөнгө, түүний өмчлөл, эзэмшил, ашиглах эрхийн талаар аливаа үр дагавар үүсгэх эрүү, иргэн, захиргааны аливаа хэрэг, маргаан үүссэн бол Банкинд мэдэгдэх;

3.2.8. Гэрээний хугацаанд гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас Барьцаа хөрөнгөд үүссэн эрсдэлийг бүрэн хариуцах бөгөөд энэ нь Гэрээний үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй;

3.2.9. Барьцааны хөрөнгийн хийц, зориулалт, загварыг нь өөрчлөхгүй, зориулалтын бусаар ашиглахгүй бөгөөд эвдэж гэмтээхгүй, ашиглалтын зөрчил гаргахгүй, худал мэдээлэл өгөхгүй байх үүрэгтэй;

3.2.10. Барьцааны хөрөнгийг бусдад давхар барьцаалах тохиолдолд Банкинд мэдэгдэх ба энэхүү Гэрээний хавсралт дахь Дараачийн барьцааны гэрээний нөхцөл (**Хавсралт -**)-ийг дараагийн Барьцаалагчид мэдэгдэж, Гэрээндээ тусгана. Энэхүү нөхцлийг тусгаагүй Дараачийн барьцааны гэрээ нь хүчин төгөлдөр бус байх ба үүнээс үүсэх аливаа үр дагаврыг банк хариуцахгүй.

3.2.11. Хуульд болон Гэрээнд заасан бусад эрх үүрэг.

ДӨРӨВ. ҮҮРГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙГ БАРЬЦААНЫ ХӨРӨНГӨӨС ХАНГУУЛАХ

4.1. Барьцааны эрх хэрэгжүүлэх үндэслэл, урьдчилсан нөхцөл:

4.1.1. Үндсэн гэрээний "Гэрээ дуусгавар болох, Гэрээний үүргийг хугацаанаас өмнө буцаан шаардах нөхцөл"-д болон холбогдох хуульд заасан барьцааны эрхийг хэрэгжүүлэх, Барьцааны хөрөнгөөс үүргийг хангуулах нөхцөл байдал үүссэн;

4.1.2. Үндсэн гэрээний хугацаа дуусгавар болсон.

4.2. Барьцааны хөрөнгөөс үүргийг хангуулах журам, арга: Энэ Гэрээний 4.1-т заасан тохиолдол үүссэнээр Банкнаас Барьцаалуулагч болон Зээлдэгчид Үндсэн гэрээний зөрчил арилгах хугацаа зааж, барьцаанаас үүргийг хангуулах тухай мэдэгдлийг хүргүүлнэ.

4.3. Барьцааны хөрөнгийг Цахим мэдээллийн санд бүртгүүлж баталгаажуулсан бол түүнээс үүргийг хангуулахдаа Банк нь ажиллагаа эхлүүлсэн тухай тэмдэглэлийг Цахим мэдээллийн санд оруулж, бүртгэлээр баталгаажсан бусад Барьцаалагчид мэдэгдэнэ.

4.4. Мэдэгдэлд заасан хугацаанд зээлийн төлбөрийг төлөөгүй бол Барьцааны хөрөнгийг акт үйлдэн Банк эзэмшилдээ авч эсхүл Барьцаалуулагчийн хадгалалтад шилжүүлэн, Барьцааны хөрөнгийг Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуульд заасны дагуу худалдан борлуулж Зээлийн гэрээний үүргийг хангуулна.

4.5. Барьцаалуулагч, Зээлдэгч нь барьцааны эрхээ хэрэгжүүлэхэд саад учруулсан, Барьцааны хөрөнгийг Банк, гуравдагч этгээдийн эзэмшилд шилжүүлэн авах боломжгүй нөхцөл үүсвэл шүүхэд хандана.

4.6. Барьцааны хөрөнгө нь хадгаламж дахь мөнгөн хөрөнгө бол мэдэгдэх хуудаст заасан хугацаа дуусмагц хуульд заасны дагуу үл маргах журмаар Үндсэн гэрээний үүргийг хангуулна.

4.7. Авлага барьцаалсан бол төлбөрийн үүргийг Банкинд шилжүүлэх тухай буюу барьцааны эрхийн тухай Үндсэн үүрэг гүйцэтгэгчид мэдэгдэх бөгөөд хуульд заасны дагуу Үндсэн үүрэг гүйцэтгэгчээс барьцааны шаардлагаа шууд хангуулна.

4.8. Хэрвээ Банк боломжтой гэж үзвэл Барьцаалуулагч, Зээлдэгчтэй тохиролцон, тэдгээрийн бичгээр өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр Барьцааны хөрөнгийг Зээлийн төлбөрт хэсэгчлэн болон бүхэлд нь тооцон шилжүүлэн авч болно.

4.9. Барьцаалуулагч нь 3.2.4-т заасан үүргээ гүйцэтгээгүйгээс үүсэх хариуцлагыг Банк хүлээхгүй бөгөөд Барьцааны хөрөнгийн өмчлөл, эзэмшил, ашиглах эрх хэнд байгаагаас үл хамааран журам зөрчигдөн шилжсэн хөрөнгөөс Банк үүргийг хангуулна.

MONGOLIA MONGOLIA 179 МОНГОЛ УЛС

ТАВ. БУСАД

5.1. Талууд гарын үсэг зурж, тэмдэг дарснаар Гэрээ хүчин төгөлдөр болно.

5.2. Үндсэн гэрээний үүрэг бүрэн биелэгдсэн, Барьцааны хөрөнгөөс Үндсэн үүргийг бүрэн хангуулсан болон хуульд заасан бусад тохиолдолд барьцааны эрх буюу Гэрээ дуусгавар болно.

5.3. Энэхүү Гэрээнд оруулах аливаа нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэж, талууд 5.1-т заасан журмаар баталгаажуулах бөгөөд тэдгээр нэмэлт, өөрчлөлт болон Гэрээний хавсралтууд нь тус Гэрээний салшгүй хэсэг байна.

5.4. Банк болон аль нэг Барьцаалуулагч харилцан тохиролцож Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, Гэрээг цуцлахад бусад Барьцаалуулагчийн хувьд Гэрээ хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ.

5.5. Гэрээний хугацаанд талуудын хооронд үүссэн аливаа саналын зөрүү, үл ойлголцлыг талууд хоорондоо харилцан тохиролцох байдлаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд үр дүнд хүрэхгүй бол Монгол улсын хуулийн дагуу Шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭГ БАЙГУУЛСАН:

ХасБанкийг төлөөлж:
Байгууллагын Банк
Хариуцсан захирал

Б.ЕРКИН

Барьцаалуулагчийг төлөөлж:
Эрдэнэс Монгол ХХК-ийн
Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч

О.ХУЛАН

МОНГОЛ УЛС
MONGOLIA
179
25 FEB 2022
.... он ... сар ... өдөр Бүртгэлийн № 312
Нийслэлийн тойргийн нотариатч
Х.Энхбаатар би энэхүү үйлдлийн
үнэн зөвийг гэрчлэв
Нотариатч .....

ХАСБАНК

ХасБанк Маягт 01422

2022 оны **БГ5004912848-01** дугаартай Барьцааны гэрээний
1 дүгээр хавсралт

БАРЬЦАА ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Барьцаа хөрөнгийн нэр, төрөл	Гэрчил гэзний дугаар	Тоо ширхэг	Чанар байдал, ашиглалтад орсон огноо	Хийц, загвар, материалын шинж	Байршил	Үнэлгээ /төгрөг/
1	Автозам ашиглалтын орлого	Өмнөговь аймгийн Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 239 км хатуу хучилттай автозамын зам ашиглалтын орлого				Өмнөговь аймаг, Цогтцэций сум	5,200,000,000
	Нийт дүн	-					**5,200,000,000**

ХасБанкийг төлөөлж:
Байгууллагын Банк
Хариуцсан захирал

Б.ЕРКИН

Барьцаалуулагчийг төлөөлж:
Эрдэнэс Монгол ХХК-ийн
Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч

О.ХҮЛАН

МОНГОЛ УЛС
MONGOLIA
179

ХАСБАНК

Ерөнхий захирал болон Зээл хариуцсан захирлын
2017 оны 02 дугаар тушаалын 5 дугаар хавсралт

ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН БАТАЛГААЖУУЛАХ ХУУДАС

Д/Д	Эргэлтийн хөрөнгийн нэр, төрөл /Сонгох/	Эргэлтийн хөрөнгийн эзэмшигч	Байршил /Борлуулалтын цэгүүд/: [Дүүрэг |хороо|Аймаг-сум| хороо|сум| байр-тоот]	Хийц загвар материалын шинж байдал, бусад тайлбар	Үнэлгээ /Төгрөг/
1	Өмнөговь аймгийн Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 239 км замын зам ашиглалтын орлого	Эрдэнэс Монгол ХХК	Өмнөговь аймаг, Цогтцэций сум	Хатуу хучилттай автозам	5,200,000,000
	Эргэлтийн хөрөнгийн нийт дүн				5,200,000,000

Огноо:

Эргэлтийн хөрөнгийн баталгаажуулалттай танилцсан банкны ажилтан:

Хасбанкны байгууллагын банкны газрын шинжээч Б.Туяа

Огноо:

Барьцаалуулагч/Барьцаалуулагчийг төлөөлж:

Эрдэнэс Монгол ХХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч О.Хулан

ЭРДЭНЭС МОНГОЛ ХХК
ERDENES MONGOL
УЛААНБААТАР ХОТ
11192797 ☎5124913

МОНГОЛ УЛС
MONGOLIA
179